

“БЛЮСКАЙ СЕКЬЮРИТИЗ ҮЦК” ХУВЬЦААТ КОМПАНИ
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ БУС ХУРЛЫН ТОГТООЛ

2022 оны 8-р сарын 11-н өдөр

№ 22/03/05

Улаанбаатар хот

КОМПАНИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ
ЧИГЛЭЛД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

Компанийн тухай хуулийн 62.1.1 заалт болон 2022 оны 8-р сарын 11-ний өдрийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлын тооллогын комиссын 22/02/04 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. Компанийн үйл ажиллагааны чиглэлд андеррайтер, сургалтын үйл ажиллагааг нэмж Санхүүгийн Зохицуулах Хорооноос холбогдох тусгай зөвшөөрлийг авч компанийн үйл ажиллагааны чиглэл болон дүрэмд нэмэлт өөрчлөлт оруулсугай.
2. Үйл ажиллагааны чиглэлд андеррайтерийн тусгай зөвшөөрлийг нэмж авч байгаа тул холбогдох дүрэм, журам батлах эрхийг компанийн ТУЗ-д олгосугай.
3. Компанийн үйл ажиллагааны чиглэлд орсон нэмэлт өөрчлөлтийг холбогдох эрх бүхий байгууллагад бүртгүүлэхийг Гүйцэтгэх захиралд даалгасугай.

ХУРЛЫН ДАРГА



У.АНАР

“БЛЮСКАЙ СЕКЬЮРИТИЗ ҮЦК” ХУВЬЦААТ КОМПАНИ
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ БУС ХУРЛЫН ТОГТООЛ

2022 оны 8-р сарын 11 өдөр

Дугаар: 22/02/06

Улаанбаатар хот

КОМПАНИЙН ДҮРЭМД НЭМЭЛТ ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ
ШИНЭЧИЛСЭН НАЙРУУЛГЫГ БАТЛАХ ТУХАЙ

Компанийн тухай хуулийн 62.1.1 заалт болон 2022 оны 8-р сарын 11-ний өдрийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлын тооллогын комиссын 22/02/04 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. Компанийн үйл ажиллагааны чиглэлд андеррайтер болон сургалтын үйл ажиллагаа нэмэгдэж байгаа тул компанийн дүрмийн шинэчилсэн найруулгыг хавсралтаар баталсугай.
2. Компанийн гаргасан болон зарласан хувьцааны тоо нь нэмж гаргах хувьцааны тоо ширхэгт үндэслэн өөрлөгдөх тул Санхүүгийн Зохицуулах Хорооны тогтоолын дагуу өөрчилсүгэй.
3. Компанийн албан ёсны хаягийг Монгол улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Жуулчны гудамж, Делта төв, 5 давхарт, 502 тоот болгон өөрчилсүгэй.
4. Компанийн дүрэмд орсон өөрчлөлтийг холбогдох эрх бүхий байгууллагад бүртгүүлэхийг Гүйцэтгэх захиралд даалгасугай.

ХУРЛЫН ДАРГА



У.АНАР

“БЛЮСКАЙ СЕКЬЮРИТИЗ ҮЦК” ХУВЬЦААТ КОМПАНИ
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ БУС ХУРЛЫН ТОГТООЛ

2022 оны 8-р сарын 11 өдөр

№ 22/02/04

Улаанбаатар хот

НЭМЭЛТ ХУВЬЦАА ГАРГАХ, ХУВЬ НИЙЛҮҮЛСЭН
ХӨРӨНГИЙН ХЭМЖЭЭНД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ

Компанийн тухай хуулийн 62.1.3 дахь заалт, 2022 оны 8-р сарын 11-ний өдрийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлын тооллогын комиссын 22/02/04 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. Компанийн хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг нэмэгдүүлэх зорилгоор хоёр тэрбум хүртлэх төгрөгийн үнийн дүн бүхий энгийн хувьцааг нэмж гаргасугай.
2. Нэмж гаргах энгийн хувьцааны дүнгээр хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг нэмэгдүүлэхийг зөвшөөрсүгэй.
3. Хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг нэмэгдүүлэх болон нэмэлт хувьцаа гаргах шийдвэрийг Санхүүгийн Зохицуулах Хороо хянан зөвшөөрсөний дараа компанийн дүрэмд нэмэлт өөрчлөлт оруулсугай.
4. Нэмж хувьцаа гаргах үнэт цаасны танилцуулага, холбогдох дүгнэлтүүдийг батлах, үнэ тогтоох, шаардах эрх хэрэгжүүлэх эрхийг компанийн ТУЗ-д олгосугай.
5. Холбогдох эрх бүхий байгууллагад бүртгүүлэхийг Гүйцэтгэх захиралд даалгасугай.

ХУРЛЫН ДАРГА



У.АНАР

“БЛЮСКАЙ СЕКЬЮРИТИЗ ҮЦК” ХУВЬЦААТ КОМПАНИ
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ БУС ХУРЛЫН ТОГТООЛ

2022 оны 8-р сарын 11-н өдөр

№. 22/03/08


Улаанбаатар хот

ШААРДАХ ЭРХ ХЭРЭГЖҮҮЛЭХ ТУХАЙ

Компанийн тухай хуулийн 62-р зүйлийн 62.1.9 заалт, 2022 оны 8-р сарын 11-ний өдрийн тооллогын комиссын ... дугаар тогтоолыг тус тус үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. Компанийн 2022 оны 8-р сарын 11 өдөр хуралдсан хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хуралд оролцоогүй болон хурлаас гарсан шийдвэртэй эсрэг саналтай байсан хувьцаа эзэмшигчид компаниас хувьцаагаа эргүүлэн худалдан авах шаардах эрх үүсэн тухай мэдэгдсүгэй.
2. Шаардах эрхийн загварыг хавсралтаар баталсугай.

ХУРЛЫН ДАРГА



У.АНАР